

# Уран зургийн хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй танилцуулга

Туршилт #3: Artwork Prospectus

Бидэнтэй холбогдох:

Phone: +976 7677 9444


E-mail: [invest@orda.mn](mailto:invest@orda.mn)

---

# Агуулга

<b>ОРДА-ийн тухай</b>	4
.....	
a. Хөрөнгө оруулалтын нөхцөл	5
.....	
b. Уран бүтээлийн танилцуулга	6
.....	
<b>Урлагийн бүтээлд хөрөнгө оруулах нь</b>	11
.....	
Урлагийн зах зээлийн танилцуулга	11
.....	
Урлагийн хөрөнгө оруулалтын давуу талууд	11
.....	
<b>Санал болгож буй урлагийн бүтээлүүд</b>	12
.....	
Уран бүтээлчдийн танилцуулга*	12
.....	
Санхүүгийн төсөөлөл	13
.....	
<b>Хөрөнгө оруулалтын үе шат</b>	15
.....	
Урлагийн бүтээлд хөрөнгө оруулахдаа анхаарах	15
.....	
Нэгж эрхээ хугацаанаас нь өмнө буцаан худалдах	16
.....	
<b>Хөрөнгө оруулалт хийхэд бид танд ямар</b>	17
.....	
Хадгалалт ба аюулгүй байдал	19
.....	
<b>Хууль эрх зүй ба эрсдэл</b>	19
.....	
Эзэмшил	19
.....	
Кастодиан	19
.....	

<b>Манай баг</b>	20
.....	
<b>Түгээмэл асуултууд</b>	22
.....	
<b>Бидэнтэй холбогдох</b>	22
.....	
<b>Хавсралт 1. Санхүүгийн дэлгэрэнгүй төсөөлөл</b>	23
.....	
<b>Хавсралт 2. Оргилын Золбоотөгөлдөр (Сонголт 1) - CV</b>	24
.....	
<b>Хавсралт 3. Түвдэндоржийн Нурмаажав (Сонголт 2) - CV</b>	28
.....	
<b>Хөрөнгө оруулалтын анхааруулга</b>	32
.....	



## WEALTH TECH

# ОРДА-ийн тухай

ОРДА бол хөрөнгө оруулагчдад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, урлагийн бүтээл, ховор цуглуулгын зүйл зэрэг уламжлалт бус хөрөнгүүдийг(альтернатив хөрөнгө) хэсэгчилсэн байдлаар хөрөнгө оруулах боломж олгодог, технологид суурилсан платформ юм. Бид мэргэжлийн болон хувийн, уламжлалт болон уламжлалт бус хөрөнгө оруулалтын хоорондох заагийг арилган, хил дамнасан хөрөнгө оруулалтын татвар, хууль эрхзүйн аливаа хүндрэлүүдийг арилгаж, хөрөнгө, хөрөнгө оруулагч хоёрыг холбох гүүр болохоор зорин хөгжүүлэлтээ хийж байна.

Манай компанийн зорилго нь хөрөнгө оруулалтыг илүү хүртээмжтэй, ардчилсан болгох бөгөөд өмнө нь зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон чинээлэг иргэдийн л оролцдог байсан ховор тансаг виски, дарс, урлагийн бүтээл гэх мэт онцгой, уламжлалт бус хөрөнгүүдийг хүн бүрт нээлттэй, мөн хүрэлцээтэй болгох юм. Бид технологи болон инновацилаг бизнес загварын тусламжтайгаар хүмүүст тэр бүр нээлттэй биш байсан боломжуудыг нээж, өөрийн санхүүгийн боллоцондоо тохирсон хөрөнгө хуримтлуулах арга замуудыг бий болгож чадна гэж итгэдэг. БНСУ-ын засгийн газрын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг K-Startup Grand Challenge 2021 хөтөлбөрийн шилдэг оролцогчдын нэгээр амжилттай шалгараад байна.

Бид хөрөнгө оруулагчиддаа 2020 оны 3 сараас хойш 2 төрлийн уламжлалт бус хөрөнгө оруулалтыг амжилттай санал болгосон нь:

- Жижиг хэмжээний үл хөдлөх хөрөнгө болон
- 2 төрлийн Шотланд сингл молт торхтой виски юм.

Энэ удаагийн хөрөнгө оруулалтаараа бид уран бүтээлч О.Золбоотөгөлдөр болон Т.Нурмаажав нарын цор ганц эх хувь бүхий уран зургуудыг сонгон та бүхэнд санал болгож байна.

### а. Хөрөнгө оруулалтын нөхцөл

	Сонголт - 1	Сонголт - 2
Уран бүтээлийн нэр	"Living with Trauma"	"Мэдрэмж"
Уран бүтээлч	О.Золбоотөгөлдөр	Т.Нурмаажав
Бүтээсэн огноо	2021	2021
Материал	Зотон тос, акрилик, коллаж	Грунт, темпер
Хэмжээ	165x250 cm	100x150 cm
Нийт үнэлгээ*	\$6,870.00**	\$3,450.00
Нэгж эрхийн тоо	687.00	345.00
Нэгж эрхийн үнэ	\$10.00	\$10.00
Хүлээгдэж буй жилийн өгөөж*** /Ам.доллар/	7.16%	7.09%

\*Холбоотой бүх зардал шимтгэлүүд багтсан.

\*\*USD 1=MNT 2,850 ханшаар хөрвүүлсэн. Төлбөр тооцоог тухайн өдрийн банкны самбарын ханшаар гүйцэтгэнэ.

\*\*\* Энэхүү өгөөжийг төстэй уран бүтээлүүдийн үнэлгээний ба өсөлтийн түүхэн тоон дээр тулгуурлан тооцоолсон. Урлагийн бүтээлийн үнэ цэн тухайн бүтээл болон уран бүтээлчийн зах зээл дээрх эрэлт, тухайн үеийн эдийн засгийн байдалтай уялдан өөрчлөгдөх магадлалтай.

## в. Уран бүтээлийн танилцуулга



### Сонголт - 1: О.Золбоотөгөлдөр “Living with trauma”

Амьдрал бидэнд жаргал зовлон, баяр баясал, эрч хүч, уйтгар гуниг, хүсэл шунал, хайр ухаарал, харуусал шаналал гээд тоолж баршгүй олон мэдрэмжүүдийг өгч, тэдгээрийг туулж мэдэрсэн цаг хугацааны хэлхээнд бид оршин тогтнож байдаг. Өнгөрсөн ба ирээдүйн заагт орших одоо цагт мэдрэмжүүд хөвөрсөөр. Цаг хугацаа урсан одоход тэрхүү мэдрэмжүүд дурсамж болон сэтгэлийн гүнд, хаалганы цаана оршино. Хэн нэгэн хаалга тогшиход, түгших бас баярлах мэдрэмж төрөх шиг, гэхдээ бас зугтаамаар. Өөрөө өөрийгөө өөр өнцгөөс харах гэж, өөрийгөө бодитоор ойлгох гэж бодол болно. Би хэн бэ, би хаана байна вэ, би юунд оршино вэ...Хаалга хаагдахад эдгээр асуултуудыг өөрөөсөө ахин дахин асуусаар хоцорно. Гэвч бүх зүйл түр зуурынх. Өөртэйгээ зөрчилдсөн он жилүүд нь өнөөдрийн Золбоог бүтээжээ. Эцэст нь үнэн байх нь өөрөө амьдралд үнэ цэнийг бүтээж байдаг. Үнэнтэйгээ нүүр тулсан он жилүүд, цаг хугацаа, мөчүүд илүү аз жаргалтай, өөрийнхөөрөө Золбоог бүтээсэн. Бүтээлийн голд томоор дүрсэлсэн үл таних эмэгтэйн фигур нь уран бүтээлчийн тухайн үеийн мэдрэмжүүдийг илэрхийлнэ. Нэвт гэрэлтэм намирсан цагаан давуун дээр хагас хэвтээ байдлаар дүрсэлсэн нь бодит болон бодит бусын дунд өөрийн дуу хоолойг эрэн урт бүрээ үлээж байгаа нь олон зүйлийг өгүүлэх шиг. Гэвч бүрээний чимээ эсрэг талд сонстох нь уг чимээ зөвхөн түүний эргэн тойрон цуурайтана, бусдад үл сонстоно. Нүүрэн дээрээ үл мэдэх хүний нүдийг онцолсон нь өөрийнхөө жинхэнэ “Би”-гээс нуугдсан гэлтэй, бодит байдлыг үл хүлээн зөвшөөрсөн гэмээр төрхийг шингээжээ. Оюун санаан дахь зөрчилдөөн, эрэл хайгуул, цөхрөл, уур бухимдал, үгүйсгэл бас хязгааргүй хүсэл... энэ бүгд “Living with Trauma” бүтээлд шингэжээ. Траума, чи бол миний амжилт.



## Сонголт- 2: Т.Нурмаажав “Мэдрэмж”

Монгол зургийн үндсэн хэв маягийг бүтээлүүддээ шингээдэг хэдий ч орчин үеийн хэллэгтэй хослуулдаг Т.Нурмаажав уран бүтээлчийн арга барил юм. Түүний бүтээлүүд хүний амьдралын бараан гэхээсээ гэгээлэг талыг, сайн сайханд тэмүүлэх тэмүүлэл, ирээдүйдээ итгэх итгэл зэрэг эерэг зүйлсийг илүүтэй мэдрүүлэх нь уран бүтээлчийн өөрийх нь амьдралд хандах хандлагатай холбоотой. Бүтээл бүрт нь амьсгал, агаар, өнгийн нарийн тоглолтууд гүн шингээстэй байдаг ба гүйцэтгэл болон дүрслэлийг маш нарийн гүйцэтгэлтэйгээр төгсгөдөг. Холоос харахад нэгэн цул зохиомж мэт харагдах ч ойртох тусам зохиомж доторхи зохиомж, өвөрмөц, жижиг деталь дүрслэлүүд нь тус бүртээ үйл явдал, утга санааг илтгэх мэт хөдөлгөөнүүд нь тун ч сонирхолтой.

Мэдрэмж бүтээлдээ амьдралын өнгө, баяр баясгалан, хайр, аз жаргал, бэрхшээл гэх зэрэг олон өнгө сүлэлдэн оршдог хэдийн ч хүн хамгийн сайн сайханд татагдаж, түүнд тэмүүлж амьдардагийг тунгаан дүрслэжээ. Хүмүүн өөрөө амьдралаас өөрийн өнгийг олж мэдэрч, амьдралаас ямар мэдрэмж авч байхаа өөрөө бүтээдэг гэсэн санааг уран бүтээлч бүтээлдээ шингээсэн ба бүтээлд дүрслэгдсэн бадам цэцэг нь шавар шалбааганд ургадаг хэдий ч ариун нандин, гэгээлэг бүхний билэгдэл болдгийг илэрхийлжээ.

## 2

## Урлагийн бүтээлд хөрөнгө оруулах нь

## а. Урлагийн зах зээлийн танилцуулга

Олон улсын урлагийн зах зээлийн нийт үнэлгээ нь 1.7 их наяд ам.доллар бөгөөд Нээлттэй хувьцаа (68.7 их наяд \$), биет алт (7.9 их наяд \$), хаалттай хувьцаа (3.4 их наяд \$)-ны зах зээлүүдийн араас дэлхийн 4 дэх том хөрөнгө оруулалтын зах зээл юм.<sup>1</sup>



Дэлхийн урлагийн хэсэгчилсэн хөрөнгө оруулалтын хамгийн том платформуудын нэг Masterworks-ийн гаргасан судалгаагаар дэлхийн контемпорэри буюу орчин үеийн урлагийн зах зээл сүүлийн 25 жилд жилийн 13.9%-аар өссөн бөгөөд уламжлалт хөрөнгө оруулалт болон хувьцааны хамгийн том индекс S&P 500 index 8.9% - аар, safe haven буюу биет алтны зах зээл 6.5%-аар өссөн байна. Энэхүү үзүүлэлт өнөөдрийн Ковидоос шалтгаалсан бага хүү, өндөр инфляци бүхий нөхцөл байдалд хөрөнгө оруулагч нарын анхаарлыг улам ихээр татаж байна.

Сүүлийн жилүүдэд урлагийн бүтээлийн хэсэгчилсэн хөрөнгө оруулалтууд эрчээ авч байгаа бөгөөд энэ нь миллениалууд болон шинэ


<sup>1</sup> Masterworks overview 2021 - Understanding art as an investment



урлагийн бүтээл цуглуулагч нар зах зээлд түлхүү оролцож эхэлсэнтэй холбоотой юм.

Hiscox 2019 оны урлагийн зах зээлийн тайландаа 35-аас доош насны буюу миллениал үеийн худалдан авагчдын 46% нь урлагийн хэсэгчилсэн хөрөнгө оруулалтыг сонирхож байна гэж дурьджээ.


Цаашлаад 30-аас доош насны залуу худалдан авагчдын талаас дээш (51%) хувь нь иймэрхүү төрлийн хөрөнгө оруулалтын сонирхож байгаа бол шинээр буюу 3 жилээс бага хугацаанд урлагийн бүтээл цуглуулж буй хөрөнгө оруулагчдын 43% нь хэсэгчилсэн хөрөнгө оруулалт сонирхож байна гэжээ. Энэхүү үзүүлэлт дээр 50 - аас дээш насны хөрөнгө оруулагчдын дөнгөж 29% нь энэ төрлийг сонирхож байгаагаас харвал урлагийн бүтээлийн хэсэгчилсэн эзэмшилд насны ялгаа томоохон байр суурь эзэлж буй нь тод харагдаж байна.



Урлагийн технологи, дижитал урлагийн зах зээл сүүлийн жилүүдэд олны анхаарлын төвд орж буй нь дээр дурьдсанчлан зах зээл дээрх залуу хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдсэн, мөн блокчейн болон бусад технологийн хөгжил эрчимжсэнтэй холбоотой юм.

Делойтт-с гаргадаг Урлаг ба санхүүгийн 2019 оны тайланд, 2013 оноос хойш Арт тек салбарын стартапуудын тоо 73%-аар нэмэгдсэн гэж дурьджээ. Тэдний хэлснээр “Урлаг болон технологийг хослуулах гэдэг шинэ ойлголт биш болжээ”.<sup>2</sup>

Блокчэйн технологийн тусламжтайгаар цахим болон биет урлагийн бүтээлийн төлбөр тооцоо, эзэмшил, гэрчилгээ, тээвэрлэлт болон хяналтын процессууд цоо шинэ түвшинд хүрсэн. Түүнчлэн бид бараг өдөр тутамдаа ямар нэг NFT<sup>3</sup> урлагийн бүтээл дуудлага худалдаанд шинэ үнийн рекорд тогтоож байгааг харж байна. Christie’s, Sotheby’s гэх мэт дэлхийн хамгийн том дуудлага худалдааны платформууд хүртэл дижитал урлагийн зах зээлд хөл тавьсан.



Жишээ дурьдвал одоогийн байдлаар дэлхийн хамгийн үнэтэй NFT-ээр Beeple-ийн “EVERYDAYS: THE FIRST 5000 DAYS” дижитал бүтээл энэ онд 69 сая ам.доллараар зарагдаж түүхэн дээд ханш тогтоожээ.

<sup>2</sup> Deloitte bank - Art and finance report 2019.

<sup>3</sup> Non-fungible tokens (NFTs) нь ямар нэг урлагийн бүтээл эсвэл цуглуулгыг илэрхийлэх онцгой, цахим хөрөнгө юм.

## Урлагийн бүтээлд хөрөнгө оруулах нь

### а. Урлагийн хөрөнгө оруулалтын давуу талууд

Урлагийн зах зээл бол түүний зах зээлийн үнэлгээ, бүтээлийн чанар, хүлээлт ирээдүйн өсөлт гээд бүх зүйл нь тухайн уран бүтээлч, галерей, цуглуулагчийн хувьд өөр өөр, дахин давтагдашгүй байдгаараа нэлээд нарийн төвөгтэй зах зээл юм. Мөн хөрөнгө оруулалтын хугацаанд бонд, хувьцаатай ижил мөнгөн урсгал орж ирэхгүйгээс гадна маш урт хугацааны дараа өгөөжөө өгдөг (энэ талаар дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй тайлбарлана). Гэсэн хэдий ч цуглуулагч, хөрөнгө оруулагч нарыг татдаг дараах ерөнхий давуу талууд байдаг байна.

## ДАВУУ ТАЛУУД

### БУСАД ХӨРӨНГҮҮДТЭЙ ХАМААРАЛ БАГА

Контемпорэри урлагийн зах зээл болон S&P 500 индексүүдийн хоорондох корреляцийн түвшин сүүлийн 25 жилд 0.01 байсан нь маш бага үзүүлэлт юм (Корреляци нь -1 ба 1-ийн хооронд байх бөгөөд 0-тэй ойрхон бол хамаарал бага,

### ИНФЛЯЦИЙН ХАМГААЛАЛТ

Урлагийн бүтээл бусад биет хөрөнгүүдтэй ижил нэлээд инфляцийн эсрэг маш сайн хамгаалалт болдог. Энэ нь валютын ханш унасан ч таны хөрөнгө өөрийн бодит үнэ цэнийг хадгална гэсэн үг юм.

### ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТЫН ЭСРЭГ УНАХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛНЭ

Монгол төгрөгийн ханш долларын эсрэг сүүлийн 5 жилд жилийн 5.8%-аар тасралтгүй унажээ. Бидний энэхүү хөрөнгө оруулалтаа ам.доллар дээр санал болгож байгаа учраас цаашид төгрөг суларсан ч таны хөрөнгө оруулалт үнэ цэнээ алдах эрсдэлийг бууруулах давуу талтай.

### УРЛАГИЙНН БҮТЭЭЛ НЬ ХҮҮГИЙН ТҮВШИН БУУРЧ БАЙГАА ҮЕД ТОХИРОМЖТОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛДОГ

Монгол улсын гадаад валютын урт хугацаат хадгаламжийн хүү сүүлийн 4 жилд тасралтгүй буурч байгаа бөгөөд өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт хүсдэг иргэд банкны хадгаламжаас илүү биет хөрөнгөд хөрөнгөө байршуулахыг илүүд үзэх хандлагатай болж байна.

## Санал болгож буй урлагийн бүтээлүүд

### а. Уран бүтээлчдийн танилцуулга\*

Бидний хөрөнгө оруулалтаар танд тус бүр 8 болон 16 жилийн туршлагатай дотоод болон гадаадад үзэсгэлэнгүүдээ гаргаж, нэр хүнд нь өсч буй мэргэжлийн зураач нарын уран зургуудыг сонгон санал болгож байна.

О.Золбоотөгөлдөрийн хувьд өөрийн карьерийг Монгол арга техникээр эхлүүлсэн ч сүүлийн үед тос, акрил, коллаж, болон уран баримлаар баяжуулан өөрийн уран бүтээлүүдээ туурвиж байгаа бөгөөд номын зураг, хэвлэлүүдэд зориулан бүтээл хийж байсан туршлагатай. Уран бүтээлч Т.Нурмаажавын хувьд монгол зургийн уламжлалт арга техникийг орчин үеийнхтэй хослуулдаг бөгөөд уран зургууд нь тод, гэгээлэг өнгө, нарийн деталь ажиллагаа ихтэй байдаг онцлогтой.

	Option 1	Option 2
Зураач	О. Золбоотөгөлдөр	Т. Нурмаажав
Төрсөн он, газар	1987, Хөвсгөл аймаг	1976, Увс аймаг
Боловсрол	<ul style="list-style-type: none"> <li>Монголын дүрслэх урлагийн дээд сургууль</li> <li>Польшийн Коперникийн нэрэмжит их сургууль</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“Соёл” урлагийн коллеж</li> <li>Монголын дүрслэх урлагийн дээд сургууль</li> </ul>
Бие даан гаргасан үзэсгэлэнгийн тоо	5	6
Бусал уран бүтээлчидтэй хамтран	Орос, БНХАУ, Өмнөд Солонгос, Тайланд, Малайз	АНУ, Вьетнам, БНСУ, Хятад, Япон

\* \*Зураач нарын дэлгэрэнгүй танилцуулгуудыг Хавсралт 2 ба Хавсралт 3 - т оруулсан бөгөөд та хөрөнгө оруулалтын эцсийн шийдвэр гаргахаасаа өмнө танилцуулгудтай сайтар танилцана уу.

## Санал болгож буй урлагийн бүтээлүүд

### а. Санхүүгийн төсөөлөл

Хөрөнгө оруулалттай холбоотой 5 жилийн туршид хөрөнгө оруулагчдаас гарах зардлууд, цэвэр ашиг болон өгөөжийн түвшний тооцооллыг дараах хүснэгтэд нэгтгэлээ. Бид тооцооллуудаа урлагийн бүтээлүүдийн үнийн өсөлт болон гарч болзошгүй зардлуудын суурь хүлээлтүүд дээр үндэслэн гаргасан болно. Санхүүгийн дэлгэрэнгүй төсөөллүүдийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Мэдээлэл	Сонголт 1	Сонголт 2	Нийт дүн
<b>Уран зургийн үнэ</b>	<b>\$5,964.91</b>	<b>\$2,982.46</b>	<b>\$8,947.37</b>
<b>Зардлууд:</b>	<b>\$905.09</b>	<b>\$467.54</b>	<b>\$1,372.63</b>
Кастодианы шимтгэл	\$74.65	\$37.32	\$111.97
Хөрөнгө удирдлагын шимтгэл	\$799.67	\$399.83	\$1,199.50
Гүйцэтгэлийн урамшуулал	\$0.00	\$0.00	\$0.00
Үнэт цаасжуулах болон бусад зардал	\$30.77	\$30.39	\$61.16
<b>Нийт зардлууд</b>	<b>\$6,870.00</b>	<b>\$3,450.00</b>	<b>\$10,320.00</b>
5 жилийн дараах үнэлгээ	\$9,606.55	\$4,803.28	\$14,409.83
Татварын өмнөх ашиг	\$2,736.55	\$1,353.28	\$4,089.83
Татвар 10%	\$273.66	\$135.33	\$408.98
<b>Татварын дараах ашиг</b>	<b>\$2,462.90</b>	<b>\$1,217.95</b>	<b>\$3,680.84</b>
Хөрөнгө оруулалтын нийт өгөөж (ROI)	35.85%	35.30%	35.67%
Хөрөнгө оруулалтын жилийн өгөөж (Annualized ROI)	7.17%	7.06%	7.13%
Жилийн нийлмэл өгөөж (CAGR)	7.16%	7.09%	7.13%

Бид мөн өгөөжийн хэд хэдэн хувилбаруудыг тооцож үзсэн бөгөөд зургуудын үнэлгээ 5%-аас 15% хүртэл өсөхөд хөрөнгө оруулалтын нийлмэл өгөөж хэрхэн өөрчлөгдөхийг дараах хүснэгтээс харна уу.

Scenario analysis

Price appreciation per year	CAGR	
	Option 1	Option 2
5%	2.48%	2.39%
8%	5.28%	5.21%
10%	7.16%	7.09%
12%	9.04%	8.98%
15%	11.88%	11.83%

Мөн цаашлаад бид хөрөнгийн багцын хувьд өгөөж хэрхэн өөрчлөгдөж болох хувилбаруудыг гаргасан ба та 2 зурагт хамтад нь хөрөнгө оруулвал дундаж өгөөж нь ямар байх бол гэж бодож байгаа бол дараах хүснэгтэд анхаарлаа хандуулна уу. Жишээлбэл, та эхний зураг 12%-аар өсч, 2 дах зураг 8%-аар өснө гэсэн хүлээлттэй байгаа бол нийт хөрөнгө оруулалт тань жилд 7.76%-ийн өгөөжтэй байна гэсэн үг юм.\*







	5%	8%	10%	12%	15%
5%	<b>2.45%</b>	4.32%	5.57%	6.83%	8.72%
8%	3.39%	<b>5.25%</b>	6.51%	<b>7.76%</b>	9.66%
10%	4.01%	5.88%	<b>7.13%</b>	8.39%	10.29%
12%	4.64%	6.51%	7.76%	<b>9.02%</b>	10.92%
15%	5.59%	7.46%	8.71%	9.97%	<b>11.86%</b>

Portfolio weighted average return variations

\*ЭНЭХҮҮ САНХҮҮГИЙН БҮХ ТООЦООЛОЛ НЬ ЗӨВХӨН ӨНГӨРСӨН МЭДЭЭЛЭЛД ТУЛГУУРЛАСАН ИРЭЭДҮЙН ТӨСӨӨЛӨЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ БӨГӨӨД ОРДА-ИЙН ЗҮГЭЭС ЯМАР НЭГ ӨГӨӨЖИЙН АМЛАЛТ, БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛНО. ДЭЛГЭРЭНГҮЙ АНХААРУУЛГЫГ ПРОСПЕКТУСЫН ТӨГСГӨЛД БҮЙ INVESTMENT DISCLAIMER-ЭЭС УНШИНА УУ.

## 4

## Хөрөнгө оруулалтын үе шат

	Хөрөнгө оруулалтын танилцуулгыг мэйлээр хүлээн авч сайтар танилцана.
	2 төрлийн урлагийн бүтээлээс сонгож, алийг нь хэр хэмжээгээр авахаа шийдэж, захиалга өгнө. Үүний тулд мэйлээр ирсэн холбоосоор нэвтрэх юм уу invest.orda.mn-ээр хандаж хөрөнгө оруулагчийн анкет болон захиалгын хуудас бөглөнө.
	Хөрөнгө оруулалтын талаар ямар нэг асуулт байвал манай сангийн менежерүүдтэй и-мэйл эсвэл утсаар ярилцах, эсвэл биеэр уулзах цаг товлож болно.
	Хөрөнгө оруулалтын гэрээг хүлээн авч танилцан, гарын үсэг зурж захиалгаа баталгаажуулах ба хөрөнгө оруулалтын төлбөрийн нэхэмжлэх хүлээн авч холбогдох дансанд төлбөрийг шилжүүлнэ.
	Урлагийн бүтээлийг худалдан авсан гэрээ болон гэрчилгээнүүдийг бид хүлээн авч Кастодиан банканд хадгалуулж, таны өмчлөлийг баталгаажуулах ба баталгаажуулсан даруйд танд мэдэгдэнэ.
	Бид таны урлагийн бүтээлийг хөрөнгө оруулалтын хугацаанд аюулгүй хадгална.

### а. Урлагийн бүтээлд хөрөнгө оруулахдаа анхаарах зүйлс

- **Хөрөнгө оруулалтын хэмжээгээ тодорхойлох**

Бонд эсхүл хадгаламжтэй харьцуулахад тодорхой, тогтмол өгөөжийг дансанд тань оруулахгүй ч гэлээ жил бүр үнэ цэнэ нь өсдөг тул та доод тал нь 5 жил хүлээнэ гэдгээ бодолцон хөрөнгө оруулахыг санал болгож байна.

- **Хугацаагаа тодорхойлох**

Урлагийн бүтээл урт хугацааны хөрөнгө оруулалтад тооцогддог тул та доод тал нь 5 жилээр төлөвлөөрэй

- **Урлагийн бүтээлийн хэсэгчилсэн хөрөнгө оруулалт гэдгийг тунгааж үзээрэй.**

Урлагийн бүтээлийг хэсэгчлэн өмчилнө гэдэг нь бэлэг юм уу гэртээ гоёлын чиглэлээр хананд өлгөх гэж уран зураг авдагаас арай өөр ойлголт юм. Биет уран зураг нь нэг бол галерей, ОРДА-ын хөрөнгө хадгалах оффис эсвэл хөрөнгө оруулагчдын харилцан тохиролцсон газарт хадгалагдах тул хэн нэгний хувийн эзэмшилд очихгүй гэдгийг санаарай.

- **Уран зургийн оюуны өмчийн асуудлыг бодолцоорой.**

Таны эзэмшилд зөвхөн биет уран зургийн өмчлөл очиж байгаа ба зохиогчийн эрх нь шилжихгүй юм. Зохиогчийн эрхийг зураач өөрөө эзэмших бөгөөд зохиогчтой гэрээгээр тохиролцоогүй тохиолдолд бүтээлийн дижитал хувилбар, мерчандайз, хувилж олшруулах гэх мэт үйлдэл хийх хориотой юм. Хэрэв энэхүү үйлдлийг хийхээр бол ОРДА-д мэдэгдэж, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр зохиогчтой харилцан тохиролцох шаардлагатай болно.

## **в. Нэгж эрхээ хугацаанаас нь өмнө буцаан худалдах тохиолдолд?**

- Та дараагийн худалдан авагчаа олж бидэнд мэдэгдснээр бид өмчлөлийг дараагийн хөрөнгө оруулагчид шилжүүлэх боломжтой.



- Эсхүл бид танд худалдан авагч олж өгөхөөр дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллах боломжтой.
- Нийт нэгж эрх эзэмшигчдийн хурлын дийлэнх олонхийн (66.7%) саналаар тухайн урлагийн бүтээлийг хаалттай худалдаа эсвэл дуудлага худалдаагаар борлуулан хөрөнгө оруулалтаа татах боломжтой.

## 5 | Хөрөнгө оруулалт хийхэд бид танд ямар ажлуудыг хийж өгч байгаа вэ?

- **Хөрөнгө оруулах урлагийн бүтээл сонгох**
- **Тодорхой уран бүтээлч ба урлагийн бүтээл сонгох**

Зах зээлийн судалгаа  
Уран бүтээлч сонгох  
Урлагийн бүтээл сонгох

- **Хөрөнгө оруулалтын хугацааг сонгох - доод тал нь 5 жил**

Хугацаа дуустал хадгалах  
Эцсийн хугацаанаас өмнө зарах

- **Зардлын шинжилгээ**

Худалдан авах  
Хадгалалт  
Тээвэрлэлт  
Татвар ба бусад

- **Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ**

Нийт хүлээгдэж байгаа өгөөж  
Ирээдүйн үнэ цэнийн төсөөлөл  
Нэгж эрхийн тооцоолол  
Шимтгэл, хураамжийн дараах цэвэр ашиг

- **Бусад**

Худалдан авах үйл явц, гэрээ, гэрчилгээ  
Татвар, хураамж  
Зах зээл дээрх хөрвөх чадварыг тодорхойлох

- **Хөрөнгө оруулалтыг гүйцэтгэх**

Танилцуулга бэлтгэх  
Урлагийн бүтээлийг худалдан авах  
Хөрөнгө оруулагчдад танилцуулах  
Худалдан авалтын төлбөрийг гүйцэтгэх  
Тайлагнал  
Тодорхой хугацааны дараа хөрөнгө оруулалтаа татахад туслах

- **Өмчлөл баталгаажуулах**

Урлагийн бүтээлийн сертификат болон гэрээг хүлээн авах  
Бичиг баримтуудыг кастодиан банкинд хүлээлгэн өгөх  
Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас  
баталгаажуулах захидал ирснээр энэхүү хөрөнгө оруулалтын  
үйл явц дуусгавар болно.


## а. Хадгалалт ба аюулгүй байдал

ОРДА-ийн зүгээс урлагийн бүтээлүүдийг хөрөнгө оруулалтын хугацаанд хадгална. Хэрэв хөрөнгө оруулагчдын дийлэнх нь зөвшөөрсөн тохиолдолд уран зургуудыг галерейд байршуулах, гадаад дотоодын үзэсгэлэнд оролцуулах, гэх мэт ажлуудыг хийж болно. Түүнтэй холбоотой зардлуудыг хөрөнгө оруулагч нар хамтран гаргана.

## 6 | Хууль эрх зүй ба эрсдэл

### а. Эзэмшил

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Санхүүгийн зохицуулах хорооны хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын хүрээнд бид урлагийн бүтээлд хөрөнгө оруулах шууд бус арга хэлбэрийг сонгосон байгааг та дараагийн хэсгээс харж болно..



## б. Кастодиан

Хууль ёсны дагуу урлагийн бүтээлийг хэсэгчлэн хуваах процессыг бид Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журмын хүрээнд бүтэцжүүлсэн болно. Ингэхдээ тус урлагийн бүтээлүүдийг

өмчилж буй компанийн хувьцаагаар баталгаажсан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг Голомт банкны кастодианд бүртгүүлэн өмчлөл болон нэгж эрхийг баталгаажуулах юм.

Кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 3 банк Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бид Голомт банкыг хамтран ажиллахаар сонгосон нь шимтгэлийн зардал бага, гадаад болон дотоод хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай, нэгж эрхийн бүртгэлийн системийг Японы Номура компаниар хийлгэсэн тул найдвар, өндөр нууцлалтай, мөн J.P Morgan олон улсын Кастодиан банкны төлөөлөгч (sub-custodian)-өөр сонгогдсон зэрэг олон шалтгаантай билээ.

## 7 | Манай баг

### Хамтран үүсгэн байгуулагч



**Гэрэлмаа**  
CEO & Үүсгэн байгуулагч  
Бодлого, Технологи, Бизнес  
Инновацийн мастерийн зэрэг, UVSQ, France  
Математикийн бакалавр, KAIST

- 2021 - **ADB болон Монгол банк** Зөвлөх  
Банкны систем, дижитал банкны дахин төлөвлөлт
- 2015- 2021 **Steppe Group** Гүйцэтгэх захирал  
Хүн төвтэй санхүү, технологийн компани
- 2019-2021 **AmCham Mongolia** ТУЗ  
ICT болон дижитал эдийн засгийн бодлого хариуцсан захирал
- 2013-2014 **OECD** Бодлогын шинжээч  
Компанийн засаглал, хөрөнгө оруулалтын орчны томоохон реформ дээр ажилласан
- 2013-2014 **UVSQ** Инновацийн мастер зэрэг  
Сэргээгдэх эрчим хүчний инновациар хэд хэдэн стартап
- 2008-2013 **KAIST** Бакалаврын зэрэг  
Математик болон Менежментийн шинжлэх ухааны хосолсон бакалаврын зэрэг



**Peter Choe**  
CTO & Үүсгэн байгуулагч  
Финтек, CS, Стартап  
UPenn CS мастер, NYU бакалавр  
KAIST CS Докторын зэрэг. ABD

- 2016-2018 **UPMC** Ахлах системийн инженер  
Өндөр ачаалалтай эрүүл мэндийн вэбсайт хөгжүүлсэн
- 2015-2016 **Seeds CTO**  
**Barclays Techstars NYC** стартапын хурдасгуур хөтөлбөрт тэнцэж, оролцсон
- 2010-2012 **atDusk** CEO/Үүсгэн байгуулагч  
Судалгаан дээр нь үндэслэн хүн хоорондын нийгмийн харилцааг сайжруулах ажил хийсэн
- 2004-2012 **KAIST** PhD ABD  
Томоохон HCI конференсуудад оролцсон (UbiComp, CHI, Mobile HCI and ACM Multimedia)

## Багийн гишүүд



**A. Хэрлэнчимэг**  
COO  
Санхүү, бодлого  
Univ. of Gloucestershire, UK  
M.B.A.



**M. Содгэрэл**  
Хөгжүүлэгч  
NYU  
BSc in Computer Science



**Б. Хүслэн**  
Хуулийн зөвлөх  
Renmin University  
Master of Laws



**A. Мөнхзориг**  
CFO  
Finance, Policy  
Asia University, Taiwan  
B.A in Financial Management



**Nathanael Tsegaye**  
Хөгжүүлэгч  
NYU  
BSc in Electrical Engineering



**Г. Нандинбилэг**  
Бизнес хөгжлийн менежер  
National Univ of Mongolia,  
BA in Accounting



**Н. Буяндэлгэр**  
Сангийн менежер  
Asia University, Taiwan  
Financial Management  
Passed CFA level II



**Б. Өгөдэй**  
Хөгжүүлэгч  
University of Chicago,  
BA in Economics



**Г. Мөнгөлжин**  
Дизайнер  
Yonsei University  
BA in Graphic Design

## Олон улсын зөвлөх баг



**Len Ball**  
Digital Change Management,  
Canadian Banking, Startups  
Wilfrid Laurier University, BA, MA



**Sung Won Park**  
NY Lawyer  
Finance JP Morgan Chase  
Credit Suisse  
NYU Stern, Finance  
and information system



**Charles Latchoumane**  
Neuroscientist  
KAIST, M.A, Ph.D



**Hyukjae Jang**  
Software Engineer at Line Plus Co  
KAIST, Ph.D in Computer Science

## 8 | Түгээмэл асуултууд

### 1. Би урлагийн бүтээлүүдээ биеэр үзэж болох уу?

- Мэдээж болно. Урлагийн бүтээлүүд ОРДА-ийн оффис дээр ихэвчлэн хадгалагдах бөгөөд та хэзээд бидэнд мэдэгдсэний үүдэн дээр ирж урлагийн бүтээлээ харах боломжтой.
- Бид Улаанбаатар дахь оффистоо хөрөнгүүдээ харах, тестлэх (боломжтой үед), ОРДА-ийн багийнхантай уулзаж, хөрөнгө оруулалт, сонирхолтой боломжуудын талаар ярилцах боломжтой ОРДА клубыг үүсгэн байгуулах бэлтгэл ажилдаа ороод байна.
- Ямар нэг шалтгааны улмаас урлагийн бүтээлийг өөр тийш шилжүүлэх болсон тохиолдолд бид таныг мэдээллээр ханган, боломжтой цагийг товлож ажиллана.

## 9 | Бидэнтэй холбоо барих

**Tel:** 976-7577-9444

**Email:** [invest@orda.mn](mailto:invest@orda.mn)

## 10

## Хавсралт 1. Financial Projection Details

Сонголт 1	2022	2023	2024	2025	2026	Total
Үнэлгээний өсөлтийн %	10%	10%	10%	10%	10%	
Хөрөнгө оруулалт USD	\$6,561.40	\$7,217.54	\$7,939.30	\$8,733.23	\$9,606.55	
Нийт орлого	\$596.49	\$656.14	\$721.75	\$793.93	\$873.32	\$3,641.64
<b>Зардлууд:</b>						
Кастодианы зардал	\$7.65	\$14.44	\$15.88	\$17.47	\$19.21	\$74.65
ХИУ зардал	\$131.07	\$144.06	\$158.47	\$174.32	\$191.75	\$799.67
Бусад зардал	\$30.77					\$30.77
Нийт зардал	\$169.50	\$158.50	\$174.35	\$191.78	\$210.96	\$905.09
Гүйцэтгэлийн урамшууллаас өмнөх ашиг	\$426.99	\$497.64	\$547.41	\$602.15	\$662.36	\$2,736.55
Гүйцэтгэлийн урамшуулал	\$0.00	\$0.00	\$0.00	\$0.00	\$0.00	\$0.00
Татварын өмнөх ашиг	\$426.99	\$497.64	\$547.41	\$602.15	\$662.36	\$2,736.55
Татвар 10%	\$42.70	\$49.76	\$54.74	\$60.21	\$66.24	\$273.66
Татварын дараах ашиг	\$384.29	\$447.88	\$492.67	\$541.93	\$596.13	\$2,462.90
<b>NAV</b>	<b>\$6,349.20</b>	<b>\$6,797.08</b>	<b>\$7,289.75</b>	<b>\$7,831.68</b>	<b>\$8,427.81</b>	

Option 2						
Үнэлгээний өсөлтийн %	10%	10%	10%	10%	10%	
Хөрөнгө оруулалт USD	\$3,280.70	\$3,608.77	\$3,969.65	\$4,366.61	\$4,803.28	
Нийт орлого	\$298.25	\$328.07	\$360.88	\$396.96	\$436.66	\$1,820.82
<b>Зардлууд:</b>						
Кастодианы зардал	\$3.83	\$7.22	\$7.94	\$8.73	\$9.61	\$37.32
ХИУ зардал	\$65.54	\$72.03	\$79.23	\$87.16	\$95.87	\$399.83
Бусад зардал	\$30.39					\$30.39
Нийт зардал	\$99.75	\$79.25	\$87.17	\$95.89	\$105.48	\$467.54
Гүйцэтгэлийн урамшууллаас өмнөх ашиг	\$198.49	\$248.82	\$273.70	\$301.07	\$331.18	\$1,353.28
Гүйцэтгэлийн урамшуулал	\$0.00	\$0.00	\$0.00	\$0.00	\$0.00	\$0.00
Татварын өмнөх ашиг	\$198.49	\$248.82	\$273.70	\$301.07	\$331.18	\$1,353.28
Татвар 10%	\$19.85	\$24.88	\$27.37	\$30.11	\$33.12	\$135.33
Татварын дараах ашиг	\$178.65	\$223.94	\$246.33	\$270.97	\$298.06	\$1,217.95
<b>NAV</b>	<b>\$3,161.10</b>	<b>\$3,385.04</b>	<b>\$3,631.37</b>	<b>\$3,902.34</b>	<b>\$4,200.40</b>	

**Хавсралт 2.****Оргилын Золбоотөгөлдөр (Сонголт 1) - CV**

О.Золбоотөгөлдөр нь 1987 онд Хөвсгөл аймагт төрсөн. 2010 онд ДУДЭС-г Ц.Нармандах багшийн удирдлаган доор Монгол зургаар мэргэшин бакалавр зэрэгтэйгээр төгссөн. 2010-2012 оны хооронд

Польш улсын Коперникийн нэрэмжит сургуулийн Дүрслэх урлагийн тэнхимд суралцсан бөгөөд 2013 оноос анхны бие даасан үзэсгэлэнгээ гарган чөлөөт уран бүтээлчээр ажиллаж байна.Тэрээр Монголд 4 бие даасан үзэсгэлэн гаргаснаас гадна ОХУ, БНХУ, Солонгос, Тайланд, Малайз зэрэг улсуудад хамтарсан үзэсгэлэнгээ гаргасан юм. Мөн Монголын Урчуудын эвлэлийн хорооны уламжлалт үзэсгэлэнгүүдэд тогтмол оролцож бгаа бөгөөд гадаадын үзэсгэлэн фестивалиудад Монгол улсыг төлөөлөн оролцож идэвхтэй уран бүтээлээ хийж бгаа уран бүтээлч юм.

Түүний үзэсгэлэн бүр нэг тодорхой концепцын дор гардаг бөгөөд эхний үзэсгэлэнгүүдээрээ гэр бүл , хайр сэтгэлийн үнэ цэнэ, хүн байгалийн харилцааны талаар өгүүлдэг байсан бол 3 дахь үзэсгэлэндээ хүний далд ухамсар, зөн совин, уран бүтээлчийн дотоод зөн совиндоо хөтлөгдөн бүтээлээ туурвидаг тухай илэрхийлсэн бөгөөд сүүлийн үзэсгэлэндээ мөн л далд ухамсарт бичигдсэн дурсамжууд насанд хүрэх үед бодит амьдралд хэрхэн нөлөөлдөг ба аливаа зүйлд ухамсарын хувьд хэрхэн хамааралд өрдтөг тухай харуулахыг хичээсэн юм. 2019 онд гаргасан 4дэхь



үзэсгэлэндээ тэрээр далд ухамсар, сэтгэл санааны эерэг сөрөг темперамент, ухамсарын хамааралын тухай илэрхийлсэн. 2021 онд яруу найрагч Э.Бүжинлхамтай хамтарсан уран бүтээлчдийн нийтийн ухамсар, хамааралыг илэрхийлсэн аудио болон хэвлэл бүхий цогц үзэсгэлэн гаргасан.

Арга барилын хувьд Монгол зургийн уламжлалт техникээр түлхүү ажиллаж ирсэн боловч одоогийн байдлаар техникүүдээ тос, акрилик, коллаж, баримал зэргээр өргөтгөн ажиллаж байна.

Мөн тэрээр номын зургийн талбарт ажилладаг бөгөөд одоогоор 10 гаруй хүүхдийн номын чимэг зураг болон номын хавтасны зураг дээр ажиллан хэвлүүлсэн байна.

### **Бие даасан үзэсгэлэн**

- 2013- Moon tale, “Pearl” галерей, Монгол улс
- 2015 - Sound Cloud, 976 Art Space, Монгол улс
- 2017 - Dream, intuition portraits, Best галерей, , Монгол улс
- 2019 - Үйл явц, Хаан галерей, Монгол улс
- 2021 - Сүнс урлал, Mongol art галерей, Монгол улс

### **Хамтарсан үзэсгэлэн**

- 2014-Уран бүтээлч Э.Амарзаяатай хамтарсан үзэсгэлэн, Blue moon галерей, Монгол улс
- 2015-Уран бүтээлч Б.Номин, Б.Баатарзориг нартай хамтарсан үзэсгэлэн, Articour галерей, Монгол улс
- 2018-Уран бүтээлч Т.Найманчулуунтай хамтарсан үзэсгэлэн, Urgel галерей, ОХУ, Якутск

## Онцлох үзэсгэлэн

- 2007-2018 “Хавар” уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн МУЭХ
- 2010-2018 Монголын үндэсний урлагийн үзэсгэлэн
- 2012-2018 “Шинэ уран бүтээлүүд” уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ
- 2013-2018 “Алтан бийр” уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ
- 2014- Өмнөд Солонгос улсын зохион байгуулсан Grand art үзэсгэлэн
- 2015- Өмнөд Солонгос улсын зохион байгуулсан Grand art үзэсгэлэн
- 2016- Шинэ уран бүтээлчдийн хамтарсан үзэсгэлэн, Өмнөд Солонгос, Бусан хот
- 2017-55 дахь удаагийн урлагийн их наадам, Бусаны урлагийн танхим, Өмнөд Солонгос, Бусан хот
- 2017 MAMF Олон улсын фестиваль, Өмнөд Солонгос, Чангвон хот
- 2018- 56 дахь удаагийн урлагийн их наадам, Бусаны урлагийн танхим, Өмнөд Солонгос, Бусан хот
- 2019- Эмэгтэй уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн МУЭХ
- 2019-Олон улсын эмэгтэй уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн, Малайз улс, Пэнан хот
- 2019-Олон улсын уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн, Малайз улс, Алор Сэтар хот

## Workshops

- 2017-Best галерей, Уран бүтээлч С.Одхүүгийн үзэсгэлэн, зохион байгуулагч
- 2018-Urgel галерей, ОХУ, Якутск

- 2019-Natya сэтгэцийн эмнэлэг, сэтгэлзүйн эрүүл мэндийн сайн дурын өдөрлөг, Тайлан улс, Хатъяа

### **Номын зургууд**

- 2010-Доктор Ай ёо, Адмон хэвлэлийн газар
- 2011-2012 Хулангийн адал явдал, Anne-Camille Souris
- 2013 Фрау Холле, Адмон хэвлэлийн газар
- 2015-2017 Зохиолч Ж.Дашдоржийн Хүүхдийн номнууд ( Stone through up, Долоон бөхтэй тэмээ, Цоохор морьтой охин)
- 2019-Б.Номингийн Маама
- 2021-Э.Бүжинлхамын хүүхдийн яруу найргийн ном

10

### Хавсралт 3.

Түвдэндоржийн Нурмаажав (Сонголт 2) - CV



#### Боловсрол:

- 1976-Увс аймгийн Улаангом сумд төрсөн.
- 1994-“Соёл” коллежийг төгссөн”
- 2005-Улаанбаатар хот СУИС-ДУДС төгссөн.

#### Бие даасан үзэсгэлэнгүүд:

- 2002-“Аниргүйгээр” уран бүтээлийн үзэсгэлэн Улаанбаатар хот
- 2007-“Халуун салхи” уран бүтээлийн үзэсгэлэн Улаанбаатар хот
- 2009-“Хязгааргүйн дунд” уран бүтээлийн үзэсгэлэн Улаанбаатар хот

- 2015-“Бодлын тэнгис” уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ үзэсгэлэнгийн танхим
- 2016-“Ертөнц”-уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ үзэсгэлэнгийн танхим
- 2018 – “Хэмнэл” уран бүтээлийн үзэсгэлэн “Хаан галерей” танхим

### **Хамтарсан үзэсгэлэн:**

- 2003 - 2020 он “Эмэгтэй уран бүтээлчдийн үзэсгэлэн” МУЭХ
- 2006 - “Гоо ертөнц” уран бүтээлийн үзэсгэлэн
- 2006 - “Их Монгол” МУЭХ Улаанбаатар хот
- 2006 - “Эрт ба эдүгээ” хамтарсан үзэсгэлэн “Монгол зургийн нийгэмлэг”
- 2006 – 2015 он “Хавар” уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн МУЭХ
- 2006 - “Шилдэг бүтээлүүд 2006” МУЭХ
- 2006 - “Монгол зураг” хамтарсан үзэсгэлэн “Монгол зургийн нийгэмлэг”
- 2007 - 2019 он “Намар” уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн МУЭХ
- 2007 - “Шилдэг бүтээлүүд 2007” уран бүтээлийн үзэсгэлэн
- 2009 - “Улаанбаатар хотын 370” уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ
- 2010 - “Шилдэг бүтээлүүд 2010”
- 2011 - “Монголын төсөөлөл” “Tibet house” Арт Галерей, New York
- 2012-Олон улсын эмэгтэйчүүдийн хамтарсан үзэсгэлэн Вьетнам,Хо ши мин хот

- 2012-“Эмэгтэйчүүдийн төсөөлөл” уран бүтээлийн үзэсгэлэн Сөүл, Солонгос
- 2012-“Урлаг ба Хайр” уран бүтээлийн үзэсгэлэн Blue Mon арт галерей
- 2012-“Blue Mon” гишүүн уран бүтээлчдийн уран бүтээлийн үзэсгэлэн
- 2012-“Шинэ уран бүтээлүүд” уран бүтээлийн үзэсгэлэн
- 2012-“Их монгол” уран бүтээлийн үзэсгэлэн Саппоро Япон
- 2013- “Хил хамгаалах байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн уран бүтээлийн үзэсгэлэн
- 2013 - “Шинэ уран бүтээлүүд” уран бүтээлийн үзэсгэлэн “Pearl” арт галерей
- 2013 - “Шинэ уран бүтээлүүд” уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ
- 2014 - Олон улсын эмэгтэйчүүдийн нэгдсэн уран бүтээлийн үзэсгэлэн
- Гуанжу Солонгос
- 2015 - “Тал нутгийн аялгуу” Хааны ордон Бээжин хот БНХАУ
- 2015 - “Талын аялгуу” Ши Ань хот БНХАУ
- 2016 - “Торгоны зам” уран бүтээлийн үзэсгэлэн МУЭХ
- 2016 - “Хамтарсан үзэсгэлэн” Blue Mon арт галерей
- 2016 - “Хятад Орос Монголын хамтарсан уран бүтээлчдийн нэгдсэн үзэсгэлэн Манжуур
- 2016 - Нармандах багшийн багшилж эхэлсний 30 жилийн ойн “Night” үзэсгэлэн
- 2017 - “Монголын сайхан орон” МУЭХ
- 2017 - “Beijing Benally” олон улсын үзэсгэлэн “БНХАУ”

- 2018 - “Монголын сайхан орон” МУЭХ
- 2018 – “ Монгол салхи” олон улсын зураачдын хамтарсан үзэсгэлэн “Баянхонгор аймаг”
- 2017 – Шавь нарын гар зургийн үзэсгэлэн “Сөүл хот БНСУ” “Ирээдүй Монгол ТББ”
- 2019 - Шавь нарын гар зургийн үзэсгэлэн “Сөүл хот БНСУ” “Ирээдүй Монгол ТББ”
- 2019 – “Өв соёл” хамтарсан үзэсгэлэн “Орд галерей”
- 2019 – Оны шилдэг бүтээлийн үзэсгэлэн “МУЭХ”
- 2020 – “Чандмань нэгдэл” хамтарсан үзэсгэлэн “МУЭХ”
- 2021 – “Wing” үзэсгэлэн “Жигүүр Гранд” групптэй хамтарсан үзэсгэлэн “Парк од Молл”

**Шагнал:**

- “Залуучуудын хөдөлмөр алтан медаль”
- 2002 Оны шилдэг бүтээл “ Уйгур соёл” УЗГ
- 2009 Оны шилдэг бүтээл “ Аялгуут нутаг” УЗГ
- 2013 Хил хамгаалах ерөнхий газрын ойн медаль
- 2012 онд Алдарт эхийн 2-р одон
- 1998-2015 он хүртэл Төрийн ёслолын албаны гадаад дотоодын зочидод зориулсан бэлгэнд бүтээлүүдээ өгч байсан.
- 2016 Оны шилдэг бүтээл “Амар амгалан” УЗГ
- 2017 Хөдөлмөрийн хүндэт медал
- 2018 Оны шилдэг бүтээл “ Цагын хүрдэн” УЗГ
- 2018 “Монголын урчуудын эвлэлийн хороо”-ны нэрэмжит шагнал

## Хөрөнгө оруулалтын анхааруулга

“ОРДА Вэлф” ХХК (цаашид холбоо хамааралтай бүх зомпаниудыг “ОРДА” гэх) нь гарутасны аппликейшн (цаашид “платформ” эсвэл “апп” гэх) дээр суурилсан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг. Бид платформоороо дамжуулан уламжлалт бус хөрөнгө оруулалтад хөрөнгийг хэсэгчилэн, эсвэл бүхэлд нь өмчлөх замаар оролцох боломжийг санал болгодог (цаашид “хөрөнгө оруулалт” гэх). Хөрөнгө оруулалтыг анхдагч болон хоёрдогч байдлаар платформ дээр санал болгоно. Энэхүү анхааруулгад манай платформоор дамжуулан үйлчилгээ авахтай холбоотой эрсдэл болон хөрөнгө оруулагч нарын зайлшгүй анхаарах ёстой зүйлсийг багтаасан болно.

Өнгөрсөн үеийн гүйцэтгэл ирээдүйн талаар ямар нэг баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагч өөрийн мөнгийг алдах эрсдэлтэй. Хөрөнгө оруулалтын төрөлжүүлэлт, хөрөнгийн хуваарилалт хийснээр ашиг олох, эсвэл алдагдал хүлээхгүй гэсэн баталгаа биш юм. Хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр тухайн хүний өөрийн зорилго, хугацаа, эрсдэл даах чадвар дээр үндэслэх ёстой.

ОРДА нь платформ дээр тавигдсан, эсвэл хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн ямар нэг хөрөнгө оруулалтын материал, танилцуулга, проспектус дээр дурьдсан аливаа хөрөнгийн багц, тоон мэдээллүүд нь ирээдүйд төсөөлсний дагуу явагдах, эсвэл үр өгөөжтэй байх талаар ямар ч амлалт, баталгаа гаргахгүй болно. Платформ дээрх бусад хөрөнгө оруулагч нарын хүртсэн өгөөжийг, эсвэл түүнтэй харьцуулахуйц ямар нэг хөрөнгө



оруулалтын гүйцэтгэлийг өөр бусад хөрөнгө оруулагч ирээдүйд хүртэнэ гэсэн үг биш юм.

Платформ дээрх хөрөнгө оруулалтууд ирээдүйд төлөвлөсөн бизнесийн зорилгоо биелүүлэх, хугацааны эцэст хөрөнгө зарагдах эсэх дээр ОРДА ямар нэг баталгаа гаргахгүй.

Хөрөнгө оруулагч нар өөрсдийн судалгааг хийж, Платформ дээрх тооцоолол, таамаглалд дангаар нь итгэж болохгүй бөгөөд бид таныг өөрн санхүүгийн зөвлөх, хуульч, нягтлан бодогч болон тухайн хөрөнгө оруулалтын эрсдэлийн талаар танд зөвлөж чадах ямар нэг мэргэжлийн хүнээс тусламж авч, ярилцахыг зөвлөж байна.

Үнийн трэнд болон бусад түүхэн дата, мэдээллүүд зөвхөн харьцуулсан загварчлалын зорилгоор ашиглагдсан болно. Гарч болох шимтгэл, зардлууд болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр бодит өгөөж, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл нь Платформ дээр төсөөлсөн дүнгээс зөрүүтэй байж болно.

Хөрөнгө оруулалтын хөрөнгө бүр онцгой бөгөөд өөрсдийн гүйцэтгэл, эрсдэл, ханшийн савалгаатай байдаг тул тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг өөр бусад хөрөнгөтэй шууд харьцуулах нь зохимжгүй гэдгийг анхаарна уу.

ИРЭЭДҮЙ ХЭЗЭЭ Ч ӨНГӨРСӨНТЭЙ ИЖИЛ БАЙДАГГҮЙ. ӨМНӨХ ӨГӨӨЖИЙН ХЭМЖЭЭ НЬ ИРЭЭДҮЙД ТИЙМ ДҮНГЭЭР ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭН ӨСНӨ, ЭСВЭЛ ЯМАР НЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ОЛНО ГЭСЭН ҮГ БИШ. ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БУЙ ҮЙЛДЭЛ БҮРТЭЭ ТА ӨӨРИЙН ОРУУЛСАН ХӨРӨНГИЙГ ХЭСЭГЧЛЭН ЭСВЭЛ БҮХЭЛД НЬ АЛДАХ ЭРСДЭЛ ХҮЛЭЭЖ БУЙГАА АНХААРНА УУ.

## Хөрөнгө оруулалтын эрсдэлүүд

Платформоор дамжуулан хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэй. Ямар нэг хөрөнгөд хөрөнгө оруулахаасаа өмнө проспектус, холбоотой татвар, зардлууд, бизнесийн болон санхүүгийн дүн шинжилгээ, танилцуулгыг анхааралтай уншиж, хянан уу. Мөн өөрийн нягтлан бодогч, хуульч эсвэл бусад зөвлөгөө өгөх боломжтой хүмүүстэйгээ урьдчилан зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Хөрөнгө оруулалтын хүрээнд дараах болон бусад эрсдэлүүд гаргах боломжтой:

- **Нэгж эрхээ буцаан зарж чадахгүй байх эрсдэл.** Платформоор санал болгож буй үнэт цааснууд нээлттэй зах зээл дээр арилжаалагддаггүй. ОРДА арилжааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр хичээн ажиллаж байгаа ч, тэр нь үргэлж амжилттай болно гэсэн баталгаагүй юм. Тиймээс хөрөнгө оруулагч нар өөрийн эзэмшиж буй нэгж эрх, үнэт цаасыг эргүүлэн зарах зах зээл хөрвөх чадвар маш бага, хязгаарлагдмал, мөн зарахтай холбоотой нэмэлт зардлууд гарч болзошгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.
- **Хөрөнгийг алдагдалтайгаар зарах эрсдэл.** Хөрөнгө оруулсан хөрөнгийн үнэ цэнэ анх авсан дүнгээс доошлох магадлалтай бөгөөд хөрөнгө оруулагч нар өөрийн оруулсан хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь алдах эрсдэлтэй. Мөн хөрөнгийн үнэ цэнэ өссөн ч өссөн дүн нь гаргасан зардлуудыг нөхөж барахгүй байх эрсдэлтэй.

- **Хөрвөх чадварын эрсдэл.** Уламжлалт бус хөрөнгийн суурь шинж чанар нь хөрвөх эрсдэл бага байх бөгөөд бидний зүгээс дараагийн худалдан авагч хүссэн үнийн дүнгээр эсвэл хүссэн хугацаанд гарч ирнэ гэсэн баталгаа гаргахгүй болно.
- **Уламжлалт бус хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлүүд.** Энэхүү эрсдэлүүдэд (i) хөрөнгийн жинэхнэ эсэх болон үүсэл гаралтай холбоотой маргаан, (ii) хөрөнгөд буруу хадгалалт, чанаргүй үйлдвэрлэл, осол, хулгай, байгалийн гамшиг, гал, болон бусад гадны хүчин зүйлсээс үүдэлтэй хоирол учрах (iii) өмчлөлтэй холбоотой хуулийн маргааны эрсдэлүүд, (iv) зах зээлийн эрсдэлүүд, (v) эдийн засгийн эрсдэлүүд (vi) залилангийн эрсдэлүүд болон бусад эрсдэлүүд орно. Бид платформ дээр санал болгох бүх хөрөнгүүдийг даатгалд хамруулахаар хичээж ажиллах ч гэсэн даатгалаар бүх эрсдэлүүдээс хамгаалж эсвэл бүх хөрөнгүүд даатгалд хамруулах боломжтой байна гэсэн амлалт гаргах боломжгүй юм.
- **Зах зээлийн трэндтэй холбоотой эрсдэлүүд.** Цуглуулагч, хөрөнгө оруулагч нарын дунд нэр хүнд өссөнөөс үүдсэн трэндийн дагуу хөрөнгийн үнэ цэн богино хугацаанд, эсвэл түр зуур өсөөд эргээд маш хурдан унах магадлалтай. Энэ төрлийн трэндийг таамаглахад бэрх бөгөөд хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.